



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021 • № 57



Б.ЛХАГВАСҮРЭН: ИНФЛЯЦ
НИЙЛҮҮЛЭЛТИЙН
ШАЛТГААНААР НЭМЭГДЭЖ
БАЙГАА ХЭДИЙ Ч ТӨВ БАНК
ИНФЛЯЦЫГ ТОГТВОРЖУУЛАХ
ЗОРИЛГОО БИЕЛҮҮЛНЭ

МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2021/02

Огноо: 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

Бодлогын хүүг хэвээр хадгалах, санхүүжилтийн хэмжээний тухай: Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эдгээрийн ирээдүйн хандлага, эрсдэлийг харгалзан үзээд: 1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах; 2. Монголбанкаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3-р улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа. Жилийн инфляц энэ оны 5 дугаар сард улсын хэмжээнд 6.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.7 хувьтай гарав. Инфляцад нэг талаас эдийн засгийн сэргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, түр зуурын шинжтэй нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц богино хугацаанд өсөх хэдий ч 2022 оноос зорилтын орчимд тогтворжино.

Дэлхийн эдийн засгийн идэвхжил сэргэж, эрдэс бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, экспортын үнэ оны эхнээс өндөр түвшинд хадгалагдаж байна. Ийнхүү гадаад орчин сайжирч, эдийн засгийн ихэнх салбар сэргэлтийн төлөвт шилжсэнээр эдийн засгийн өсөлт энэ оны эхний улиралд хүлээлтээс өндөр гарлаа. Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээний нөлөө, гадаад орчны сэргэлтийг тусган эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүллээ. Гэхдээ КОВИД-19 цар тахлын дотоод тархалттай холбоотойгоор эдийн засгийн салбаруудын өсөлт харилцан ялгаатай, цаашдын төлөв жигд бус байгаагийн дээр тодорхой бус байдал буурахгүй байна.

Төв банкны зүгээс КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахаар шат дараатайгаар авч хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд, шинээр нэвтрүүлсэн санхүүжилтийн хэрэгслүүд, санхүүгийн хөнгөлөлтийн зохицуулалтууд нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна. Мөнгөний бодлогын одоогийн төлөв нь инфляцын зорилттой нийцтэй байгаа бөгөөд цаашид эдийн засгийн идэвхжил, төлөвтэй уялдуулан инфляцын зорилтыг хангахад чиглэсэн бодлогын тохируулгыг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

“МӨНГӨН ТЭМДЭГТИЙН
ТАНХИМ” –ТАЙ БОЛЛОО



19

**МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ**

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР



29

**ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ**

УЛС ОРНУУДЫН
ИНФЛЯЦЫН ТӨЛӨВ
БАЙДАЛ



13

БАЙР СУУРЬ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙН
ТАЛААР ЭДИЙН
ЗАСАГЧДЫН БАЙР
СУУРЬ



10

ЯРИЛЦЛАГА

Б.ЛХАГВАСҮРЭН:
ИНФЛЯЦ
НИЙЛҮҮЛЭЛТИЙН
ШАЛТГААНААР ТҮР
ХУГАЦААНД НЭМЭГДЭЖ
БАЙГАА ХЭДИЙ Ч ТӨВ
БАНК ИНФЛЯЦЫГ
ТОГТВОРЖУУЛАХ
ЗОРИЛГОО БИЕЛҮҮЛНЭ



15

АСУУЛТ, ХАРИУЛТ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ШИЙДВЭР
ТАНИЛЦУУЛАХ
ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

23

**МОНГОЛБАНК ЮУ
ХИЙДЭГ ВЭ?**

А.ЭНХЖИН: ГАДААД
ВАЛЮТЫН ЦЭВЭР
ОРОХ УРСГАЛ
ӨМНӨХ 5 ЖИЛИЙН
ДУНДЖААС 450
САЯ ОРЧИМ
АМ.ДОЛЛАРААР ИХ
БАЙНА

34

**СУДАЛГАА
ШИНЖИЛГЭЭ**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД
СЕКТОРЫН
ШИНЖИЛГЭЭ

“МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ТАНХИМ” –ТАЙ БОЛОО



Монголбанкны Эрдэнэсийн сангийн дэргэд “Мөнгөн тэмдэгтийн танхим”-ыг нээлээ. Тус танхимд Эрдэнэсийн санд хадгалагдаж буй эртний зоос, Монгол Улсад төлбөрийн хэрэгслээр ашиглагдаж байсан эд зүйлс, цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт, дурсгалын зоос зэрэг нэн ховор, түүхэн ач холбогдолтой үзмэрийг дэлгэжээ. Үзмэрийн танхимд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглаж холограмм утгагч, хөтөч, 6D хэмжээст хөдөлгөөн мэдрэгчид суурилуулсан төлбөрийн хэрэгсэл, түүнтэй холбоотой танин мэдэхүйн контент, интерактив самбар болон AR дэлгэцэнд суурилуулсан “Санхүүгийн боловсрол, мультимедиа контентын үндсэн аппликейшн” зэргийг нэвтрүүлсэн байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Монголбанкны Хяналтын зөвлөл (ХЗ)-ийн ээлжит хурал болж, Монголбанкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих чиг үүргийн хүрээнд 2020 оны тайлантай танилцав. Энэ үеэр Монголбанкны үйл ажиллагааны талаар сүүлийн 3 жилийн хугацаанд гадаадын байгууллага, зөвлөхүүдийн ирүүлсэн санал, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсож, санал солилцжээ.

“АВТОМАТ КЛИРИНГ ХАУС СИСТЕМИЙН ДҮРЭМ” ШИНЭЧЛЭГДЭВ




Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-128 дугаар тушаалаар, Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 5308 дугаар бүртгэлтэй “Автомат клиринг хаус системийн дүрэм”-ийг шинэчлэн баталлаа. Энэ дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А-156 дугаар тушаалаар Монголбанк болон Автомат клиринг хаус системийн нийт оролцогч 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахаар болов.

“ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ-2021” АЯНЫГ ЭХЛҮҮЛЭВ



Монголбанк, Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран залилах болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам нягтал-2021” дөрөв дэх удаагийн аяныг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд зохион явуулж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдэд хувийн мэдээлэл алдагдвал үүсэх эрсдэл, учрах хохирлыг таниулах, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, залилах болон цахим гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдэд анхааруулах зорилгоор 2019 онд “Ятгах тусам нягтал”, 2020 онд “Нягтлах тусам аюулгүй”, “Ятгах тусах нягтал-2” аяныг Цагдаагийн Ерөнхий газар, Монголбанк, банкууд хамтран зохион байгуулж, үүний үргэлжлэл болгон “Ятгах тусам нягтал-2021” 2021 оны 10-р сарын 31-ний өдрийг дуустал зохион байгуулахаар боллоо.

○ САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит бус хурал 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Монголбанканд боллоо. Тус хуралд Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн болон бусад албаныхан оролцов. Ээлжит бус хурлаар макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөв, анхаарах асуудлуудын талаар хэлэлцэж, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах чиглэлээр харилцан мэдээлэл солилцов. Түүнчлэн, хоёр чиглэлээр ажлын хэсэг байгуулж, хуулийн төсөл боловсруулахаар тогтов.

○ МОНГОЛБАНКНААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭСЭГЧЛЭН СУНГАЛАА



Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу банкуудад “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаагаар мөрдүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэлээ. Ингэснээр банкуудад эзэлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг нээлттэй үлдээлээ. Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг /90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицууллаа. Түүнчлэн банкуудад түр хугацаанд мөрдүүлж байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа болон экспортын аккредитивт хамаарах хөнгөлөлттэй зохицуулалтыг тус тус хэвийн горимд шилжүүлээд байна.

○ ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХҮҮТЭЙ ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ 2021 ОНЫГ ДУУСТАЛ ДАХИН ХОЙШЛУУЛАВ



Монгол Улсын Их Хурлын 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунган баталлаа. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах, өрхийн орлогод дэмжлэг үзүүлэх, зээлийн эргэн төлөлт тасалдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанкнаас холбогдох байгууллагуудтай хамтран Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр дахин хойшлуулахаар шийдвэрлэв.

“ЭС ЭНД ПИ” АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ “В”, ТӨЛӨВИЙГ “ТОГТВОРТОЙ” ХЭВЭЭР ҮЛДЭЭСНИЙГ БАТАЛГААЖУУЛЛАА



Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Эс энд Пи” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В”, төлөвийг “Тогтвортой” хэвээр үлдээснээ 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдөр зарлав. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал тогтвортой байгаа гэдгийг дараах үндэслэлүүдээр тайлбарласан байна. Үүнд:

1) Монгол Улсын эдийн засаг цар тахлаас шалтгаалан 2020 онд 5.4%-иар буурсан ч дэлхийн эдийн засгийн сэргэлт, эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөгөөр 2021 онд 6.7%, 2022 онд 7.0%-д хүрэхээр байна. 2) Монгол Улсад энэ оны 4 дүгээр сараас Ковид-19-ийн тархалт нэмэгдэж эхэлсэн хэдий ч гадаад сектор, улсын төсөв, гадаад өр зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд 2021 оноос сайжирч байгаа тул эдийн засгийн сэргэлт цаашид үргэлжилнэ гэж үзэж байна. Уг сэргэлтэд Монгол Улсын вакцинжуулалтын түвшин, төсвийн зарцуулалтын арга хэмжээнүүд, дэлхийн эдийн засгийн сэргэлтээс үүдэлтэй эрдэс бүтээгдэхүүний экспортын өсөлт зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлнө. 3) Монгол Улсын вакцинжуулалтын түвшин бусад хөгжиж буй улсуудтай харьцуулахад өндөр байгаа нь цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн тодорхой бус байдлыг бууруулж байна. Монгол Улсын нийт иргэдийн дор хаяж гуравны хоёр хувь нь вакцины нэг тунг хийлгэсэн бөгөөд 60-аас дээш хувь нь вакцинд бүрэн хамрагдсан байна. 4) Уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр дунд хугацаанд эдийн засгийн төлөв харьцангуй таатай байхаар байна. Таван толгой болон Оюу толгойн уул уурхайн төслүүд дэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт 2024 он хүртэл дунджаар 6.8%-ийн орчимд байхаар байна. Мөн нэг хүнд ногдох ДНБ-ээр ижил төстэй бусад улсуудтай харьцуулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд өндөр байхаар төсөөлж байна. 5) Монгол Улсын Засгийн газар гадаадын хөнгөлөлттэй санхүүжилтүүдийг амжилттай татсанаар зарим өндөр дүнтэй гадаад өрийн эрсдэлээ бууруулж чадлаа. Тухайлбал, Монгол Улсын нийт гадаад өрийн урсгал дансанд эзлэх хувь 2020 онд 181 хувьд хүрч 2019 оны түвшнээс өссөн хэдий ч уг үзүүлэлт 2021 онд 159 хувьд хүрч буурахаар байна. 6) Монголбанк 2020 оны 8 дугаар сард Хятадын Ардын Банктай хийсэн 15 тэрбум юанийн своп хэлцлийг 2023 он хүртэл амжилттай сунгасан нь гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулсан зэрэг үндэслэлүүдийг авч үзжээ.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭНГИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ



2021.06.23

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Цар тахлаас үүдэлтэй нийтийн эрүүл мэндийн хямралаас шалтгаалсан эдийн засгийн хямралыг даван туулахтай дэлхий нийтээр тэмцэж байна. Цар тахалтай нүүр тулсан 2020-2021 онд Монголбанкнаас мөнгөний бодлого, макро зохистой бодлого, санхүүгийн зохицуулалтын арга хэмжээг мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлж буй арга хэмжээний үндсэн зорилго нь эдийн засгийн агентуудын санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлэх, хүндрэлийг хохирол багатай даван туулж, сэргэлтийн хугацааг ойртуулахад чиглэж байна. Монголбанкнаас дангаар болон Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээнүүд үр дүнд хүрч байгааг уналтаас сэргэлтийн төлөвт шилжиж буйг илэрхийлж буй эдийн засгийн үзүүлэлтүүд тодоор харуулж байна. Монголбанкнаас хямралын эсрэг хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний эерэг үр нөлөө ирэх оны эхний хагас хүртэл үргэлжлэн гарах юм.

Цаашид Монголбанкны зүгээс эдийн засгийн сэргэлтийн төлөвтэй уялдуулан дунд хугацааны инфляцын зорилтоо биелүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

Төв банкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 6-р сарын ээлжит хурлын шийдвэр, уг шийдвэрийг гаргахад гол үндэслэл болж буй эдийн засгийн дотоод, гадаад орчин, цаашдын төлөв, хандлага хэрхэн өөрчлөгдөж буй талаар Монголбанкны байр суурийг Та бүхэнтэй хуваалцаж байна.

Дотоод эдийн засгийн орчны байдлыг инфляц, түүний төлөв хэрхэн өөрчлөгдөж байгаагаас эхлэн байр сууриа хуваалцъя.

Инфляцын өсөлтийг нийлүүлэлтийн хүчин зүйлс голлон тайлбарлаж байгаа ч цаашид эрэлтийн нөлөөгөөр инфляц алгуур сэргэж Төв банкны зорилтын орчимд тогтворжино. Инфляц энэ оны

5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.2 хувь, Улаанбаатар хотод 6.7 хувьд хүрч өнгөрсөн улирлуудын бага түвшнээс нэмэгдлээ. Инфляцын өсөлтөд нэг талаас эдийн засгийн сэргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, нэг удаагийн шинжтэй нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс тайлбарлаж байна. Тухайлбал, хэрэглээний сагсны 19 хувийг бүрдүүлдэг шатахуун, мах, сайжруулсан түлшний үнэ нийт инфляцын 43 хувийг тайлбарлаж байна. Цаашид 2021 оны 4 болон 2022 оны 1 дүгээр улиралд суурь үеийн нөлөөгөөр инфляц Төв банкны зорилтыг давж болзошгүй байгаа хэдий ч 2022 оны сүүлийн хагасаас Төв банкны зорилтын орчимд тогтворжино. Өнөөгийн бодлогын төлөв нь инфляцын зорилттой нийцтэй байгаа бөгөөд эдийн засгийн идэвхжилтэй уялдуулан бодлогын тохируулгыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлсэн хэдий ч КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт эмзэг, жигд бус байна. Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээ, гадаад орчны сэргэлттэй уялдуулан эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлээ. Эдийн засгийн өсөлт 2021 оны 1 дүгээр улиралд төсөөллөөс өндөр гарсан хэдий ч цар тахлын дотоод тархалттай холбоотойгоор төсөөллийн тодорхой бус байдал нэмэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй. Өрхийн хэрэглээ сүүлийн хоёр улирал дараалан агшаад байгаа нь өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн бол хөрөнгө оруулалт сэргэж, цэвэр экспорт нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн байна. Түүнчлэн уул уурхайн салбараас гадна уул уурхайн бус ихэнх салбар уналтаас өсөлтийн төлөвт шилжиж байна. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв КОВИД-19-ын дотоод тархалтын нөхцөл байдлаас өндөр хамааралтай үйлчилгээний салбар, түүнийг дагасан ажил эрхлэлт, өрхийн орлого, хэрэглээнээс хамааралтай байна. Мөнгө, сангийн бодлого, санхүүгийн зохицуулалтын арга хэмжээ, гадаад орчны сэргэлтийг даган уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийн сөрөг зөрүү 2-3 улирлаар наашилж

2022 оны эхнээс хаагдах хүлээлттэй байна. 2021 оны 4 дүгээр сард бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нь 2 дугаар улирлын эдийн засгийн идэвхжлийг сааруулах нөлөө үзүүлсэн ч вакцинжуулалт үргэлжилж, хөл хорионы дэглэм суларснаар оны сүүлийн хагаст эдийн засаг аажмаар сэргэх суурь хүлээлт хэвээр байна.

Ирэх онд уул уурхайн салбар дахь нөөцийн агууламжийн өөрчлөлттэй холбоотойгоор тус салбарын өсөлт саарах хэдий ч уул уурхайн бус салбарын өсөлт ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг тэтгэнэ. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлогын өсөлт эдийн засгийн дотоод эрэлтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлнэ.

Бодлого, зохицуулалтын арга хэмжээний нөлөөгөөр санхүүгийн нөхцөл зөөлөрч байгаа нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж байна. 2021 оны 5 дугаар сарын байдлаар M2 мөнгө жилийн 30 хувиар нэмэгдсэн бөгөөд гадаад эдийн засгийн орчин сайжирч төлбөрийн тэнцлийн ашиг нь мөнгөний нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрийг өсгөж байна. Мөн эдийн засгийн идэвхжил болон “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт сэргэж, өнгөрсөн онд 4-5 хувиар агшиж байсан нийт зээлийн үлдэгдэл жилийн 6.2 хувиар өссөн байна. Түүнчлэн, шинээр олгосон зээлийн дундаж хүү 5 дугаар сарын байдлаар 11.5 хувь болж, 1 дүгээр сарын түвшнээс 4 орчим нэгж хувиар бага байна.

Худалдааны түнш орнуудын эдийн засгийн сэргэлт нь гадаад тэнцэлд эерэг нөлөө үзүүлж байна. АНУ, БНХАУ, Евро бүс зэрэг том эдийн засгуудын өсөлт 2021 оны 1-р улиралд хүлээлтээс өндөр байсны зэрэгцээ 2021 оны төсөөллөө сайжруулж байна. Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор хөгжингүй болон эрчимтэй хөгжиж буй орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ болон эрчимжиж буй вакцинжуулалт сэргэлтэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хэдийгээр гадаад орчинд цар тахлын шинэ давалгаанууд үүсч идэвхжилд сөргөөр нөлөөлж байгаа боловч тархалтыг хяналтад оруулах арга

хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн сэргэлтийн хүлээлт сайжирсаар байна. Гэвч улс орон бүрийн хувьд нөхцөл байдал харилцан адилгүй сэргэлт жигд бус хэвээр байна. Цаашид КОВИД-19 вирусын эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байна.

Бодлогын шийдвэр гаргаж байсан өмнөх үетэй харьцуулахад дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл энэ онд 0.5 нэгж хувиар, ирэх онд 0.1 нэгж хувиар нэмэгдэж ойрын 2-3 жилд гадаад эрэлтийн эрч хадгалагдах хандлагатай байна. Олон улсын санхүүгийн байгууллагуудын дундаж төсөөллөөр 2021 онд АНУ 6.1 хувь, Евро бүс 4.3 хувь, БНХАУ 8.5 хувийн эдийн засгийн өсөлт үзүүлэхээр байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг 6.1 хувь болж нэмэгдэхэд голлон нөлөөлж байна.

Дэлхийн эдийн засгийн идэвхжил эрчимжиж, эрдэс түүхий эдийн эрэлтийг нэмэгдүүлж, зэс, нүүрс, төмрийн хүдэр, газрын тос зэрэг манай экспортын бүтээгдэхүүний үнийг өсгөж байна. Энэ оны 4 дүгээр сарын байдлаар экспортын үнэ 53.2 хувиар, импортын үнэ 7.4 хувиар өсч, гадаад худалдааны нөхцөл 42.6 хувиар жилийн өмнөх үеэс сайжирлаа. Улмаар гадаад худалдааны нөхцөл 2021 онд ийнхүү сайжрах хүлээлттэй байгаа нь зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дэлхийн эдийн засаг, худалдааны түнш орнуудын эдийн засгийн сэргэлт төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлж байна. Мөнгө, санхүү, төсвийн бодлогын арга хэмжээнээс гадна санхүүгийн болон худалдааны хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж буй түнш, олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэг, бодлогын арга хэмжээний үр дүнд төлбөрийн тэнцэл 1 дүгээр улиралд 170.4 сая ам.доллар буюу ДНБ-ий 1.3 хувьтай тэнцэх ашигтай гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 520.6 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Энэ оны эхнээс эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор импорт тэлсэн хэдий ч экспортын орлого харьцангуй сайн гүйцэтгэлтэй байгаа нь

урсгал дансны алдагдал буурахад нөлөөлж байна. Түүнчлэн, ГШХО болон гадаад зээлийн ашиглалт өмнөх оны мөн үеэс нэмэгдэж, санхүүгийн тэнцэл 408.4 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөллөө. Монголбанкны төсөөллөөр төлбөрийн тэнцэл энэ онд 500 орчим сая ам.долларын ашигтай гарах хүлээлттэй байна.

Миний бие илтгэлийнхээ төгсгөлд цар тахлын хямралыг даван туулахад бидэнтэй идэвхтэй хамтран ажиллаж, дэмжиж буй түнш улс орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудад талархсанаа илэрхийлье. Цар тахлын энэ хүндрэлийг сайн хөршийн, сайн түншийн харилцаагаа улам бүр нягтруулж хамтын хүчээр амжилттай даван туулна гэдгийг онцлон тэмдэглэж илтгэлээ өндөрлөө.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.ЛХАГВАСҮРЭН: ИНФЛЯЦ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШАЛТГААНААР НЭМЭГДЭЖ БАЙГАА ХЭДИЙ 4 ТӨВ БАНК ИНФЛЯЦЫГ ТОГТВОРЖУУЛАХ ЗОРИЛГОО БИЕЛҮҮЛНЭ

Монголбанкны ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэнтэй ярилцав.

Сүүлийн саруудад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсч, инфляц нэмэгдэж байна. Үүнд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?

Инфляцын хөдөлгөөнийг ерөнхийд нь харвал 2019 оны сүүлээс тогтворжиж, алгуур буурах хандлагатай болж ирсэн. 2020 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас эдийн засгийн идэвхжил суларсны зэрэгцээ зарим бараа, бүтээгдэхүүний үнэд зохицуулалтын арга хэмжээ авсантай холбоотойгоор инфляц 2-3 хувьд хүрч буурсан. Харин энэ оны 4 дүгээр сараас мах, хатуу түлш, шатахуун гэсэн

цөөн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор инфляц цар тахлын өмнөх үеийн түвшин рүү хүрч сэргээд байна. Жишээлбэл, 2021 оны 6 дугаар сарын байдлаар инфляц улсын хэмжээнд 6.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 7.1 хувьтай байгаа бөгөөд үүнийг задлан харвал махны үнэ 2.1 нэгж хувь, хатуу түлш 0.5 нэгж хувь, шатахуун 0.4 нэгж хувь буюу үндсэндээ нийт инфляцын 3.0 нэгж хувь буюу 40 хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний болон хүнсний бусаар ангилан авч үзвэл хүнсний инфляц 13.1 хувь, хүнсний бус инфляц 4.7 хувьтай байна.

-БНХАУ-тай залгаа хилийн боомтууд дээр саатал үүссэнтэй холбоотойгоор зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, үнэ хөөрөгдөх хандлага бий болж байгаа нь хэрэглээний үнэ өсөхөд нөлөөлж байна. Цаашид иймэрхүү байдлаар нийлүүлэлтийн тасалдал, доголдлын улмаас инфляц хөөрөгдөж, Төв банкны зорилтоос давах тохиолдолд Төв банк бодлогоо чангаруулах уу?

-Мөнгөний бодлогын төлөвийн хувьд таны асуусантай холбогдуулж хэлэхэд, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтөд мөнгөний бодлогоор

хариу үйлдэл үзүүлэх шаардлага бага юм. Энэ ч утгаараа зарчмын хувьд хэрэглээний сагснаас нийлүүлэлтийн шалтгаантайгаар үнэ нь өөрчлөгдсөн бараа бүтээгдэхүүнийг ялган эдийн засгийн идэвхжил, эрэлтийн өсөлттэй хамааралтай инфляцыг тооцож, мөнгөний бодлогын шинжилгээ, шийдвэр гаргалтад ашигладаг. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлт, тээвэр зэрэгтэй холбоотой үнийн өсөлтийн хувьд тухайн шалтгааныг нь шийдвэрлэснээр үүнтэй холбоотой үнийг тогтворжуулах нь зүйтэй. Ингэснээр эдийн засгийн сэргэлтийг дэмжсэн бодлого үргэлжлэх боломжийг бүрдүүлнэ. Таны хэлсэнчлэн хилийн боомтууд дээрх саатлын улмаас тээвэр, логистикийн зардал нэмэгдэж, зарим импортын барааны үнэ өсөх хандлага энэ оны 4 дүгээр сараас ажиглагдаж эхэлсэн нь импортын барааны үнийн өсөлтөөс харагдаж байна.

-Нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтөд мөнгөний бодлогоор хариу үйлдэл үзүүлэх боломж хомс гэдгийг тодруулж өгнө үү?

-Нийлүүлэлтийн шинж чанартай инфляцыг мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан удирдах оролдлого нь шалтгааныг эмчлэхгүй. Мөнгөний бодлогын арга хэрэгсэл нь эдийн засгийн хэт халалт болон хөрөлтөөс үүдэлтэй инфляцад хариу үйлдэл үзүүлж, зорилтот түвшний орчимд тогтворжуулахад

чиглэгддэг. Түүнчлэн, бодлогын хүүний хариу үйлдэл нь дор хаяж 3-4 улирлын дараа бодит эдийн засагт нөлөөлдөг тул түр зуурын шинжтэй инфляцын өөрчлөлтөд Төв банк хариу үйлдэл үзүүлэх нь буруу юм. Иймд дунд хугацаанд инфляц зорилтоос хэр хазайхаас хамаарч бодлогын төлөвийг өөрчлөх шаардлага үүснэ. Бидний тооцооллоор нийлүүлэлтийн болон нэг удаагийн хүчин зүйлсийн нөлөөгөөр ирэх улирлуудад инфляц нэмэгдэх боловч дунд хугацаанд инфляц Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлт хэвээр байна. Товчхондоо, нийлүүлэлтийн шалтгаантай уялдуулж бус эдийн засгийн сэргэлттэй уялдуулж бодлогын тохиргоог хийнэ.

-Тэгвэл эрэлтийн шалтгаантайгаар үнэ хөөрөгдөх эрсдэл хэр байна вэ. Инфляцын төлөвт нөлөөлөх хүчин зүйлс, цаашдын эрсдэлийн талаар авч үзвэл?

-Эдийн засгийн сэргэлттэй уялдан эрэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэх ч харьцангуй алгуур байна гэж харж байна. Харин зөвхөн Монгол Улсыг бус дэлхий нийтийг хамарсан тээвэр, логистикийн асуудал нь инфляцын цаашдын төлөвт голлох эрсдэлийг үүсгэж болзошгүй байна. Энэ жилийн хувьд оны эцэс рүү инфляц Төв банкны зорилтын дээд интервал болох 8 хувьд хүрэх хэдий ч ирэх оны сүүлийн хагаст голч зорилт 6 хувийн түвшин рүү

“Энэ жилийн хувьд оны эцэс рүү инфляц Төв банкны зорилтын дээд интервал болох 8 хувьд хүрэх хэдий ч ирэх оны сүүлийн хагаст голч зорилт 6 хувийн түвшин рүү буурна.”

буурна. Одоогийн байдлаар эрэлтийн шалтгаантай инфляцын хувьд суурь инфляцын дарамт сэргэж байгаа ч харьцангуй бага байна. Тухайлбал, нэгдүгээр улирлын эдийн засгийн өсөлт Монголбанкны хүлээлтээс өндөр гарсан, үүнтэй уялдуулан төсөөллөө ч нэмэгдүүлсэн. Үүнтэй уялдуулан Төв банк репо санхүүжилтийн хэмжээг 350 тэрбум төгрөгөөс 250 тэрбум төгрөг болгож бууруулсан. Энэ нь бодлогын тохиргоог нийлүүлэлтийн инфляцтай уялдуулж бус эдийн засаг, эрэлтийн сэргэлттэй уялдуулж, түүнээс шалтгаалсан инфляцтай уялдуулж хийх дохио юм.

-Дэлхийн улс орнуудад бас инфляц нэмэгдэх хандлага бий болж байна. Одоогоор Монголбанкны хувьд мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах нөхцөл үүсч байна уу. Цаашдын бодлогын төлөвийг хэрхэн харж байна вэ?

-Тийм ээ. Дэлхийн ихэнх улс орнуудын хувьд энэ оны 4 дүгээр сараас инфляцын түвшин нэмэгдэх хандлага ажиглагдлаа. Тухайлбал, инфляц АНУ-д 2.6 хувиас 5.3 хувь, эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнууд буюу OECD-ын улсуудад 3 дугаар сарын инфляц 2.4 хувь байсан бол 4, 5 дугаар саруудад харгалзан 3.3-3.8 хувь, Европын орнуудын хувьд 3 дугаар сард 1.3 хувь байсан бол 6 дугаар сард 1.9 хувь болж өссөн байна.

Европын орнуудын инфляцын түвшин цар тахлаас өмнөх үеийн түвшин рүүгээ очсон дүр зурагтай байгаа бол OECD болон АНУ-ын инфляцын түвшин 2008 оноос хойших хамгийн өндөр түвшиндээ хүрлээ. АНУ-ын төв банк үүний шалтгааныг эдийн засгийн сэргэлт болон дотоодын шатахууны үнийн өсөлттэй холбон тайлбарлаж байгаа бөгөөд энэ оны сүүлээр 2 хувь орчимд хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Дэлхийн улс орнуудад инфляц нэмэгдэж эхэлснийг эрэлт болон нийлүүлэлтийн хэд хэдэн нийтлэг шалтгаантай холбон тайлбарлаж байна. Цар тахлаас шалтгаалан улс орнууд 2020 оны эхэн үеэс эхлэн хөл хорио тогтоосноор ААН, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хязгаарлаж, эдийн засгийн идэвхжлийг сааруулсан. Харин энэ оны эхнээс хүн амыг вакцинжуулах үйл явц эрчимжиж, хөл хориог бүрэн болон хэсэгчилсэн байдлаар сулруулснаар эдийн засаг сэргэж, эрэлт талаас суурь үеийн нөлөөгөөр болон түр зуурын шинжтэйгээр инфляц нэмэгдсэн. Нийлүүлэлт талаас түүхий эд, бараа материалын үнийн өсөлт инфляцыг хөөрөгдсөн байх талтай гэж төв банкууд үзэж байна. Гэхдээ энэхүү инфляцын өсөлтийг дэлхийн төв банкууд түр зуурын шинжтэй гэж үзэж байгаа бөгөөд бодлогын хүүг яаран өсгөхгүй гэдгээ мэдэгдээд байна.

Монголбанкны хувьд мөн адил нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө ирэх оноос арилж, инфляц 2022-2023 онд тогтворжино гэж үзэж байгаа бөгөөд цаашдын бодлогын арга хэмжээ инфляц дунд, урт хугацаандаа зорилтоос хэт хазайхгүй байх, ужгирсан инфляцыг өдөөхгүй байхад чиглэгдэж, бодлогын тохируулгыг хийж ажиллана.

-Ярилцсанд баярлалаа.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСАГЧДЫН БАЙР СУУРЬ



Монголбанкны
ЭЗССХ-ийн
захирал
С.ДЭМБЭРЭЛ

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эдгээрийн ирээдүйн хандлага, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Монголбанкаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3-р улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэрийг гаргаад байна. Мөнгөний бодлогын шийдвэрийн талаар эдийн засагчдын байр суурийг хүргэж байна.

2021 оны эдийн засгийг зөвхөн өсөлтийн тоогоор нь биш өсөлтийн агуулга талаас нь харвал тогтвортой бус, хүртээмжтэй биш байхаар байгаа тул мөнгөний бодлогын зохицсон төлөвийг хадгалах нь зүйтэй. Оны эцсээр дараа оны төлөвийг нейтрал төлөвт шилжүүлэх эсэхийг шийдэх хэрэгтэй.

Инфляцын хувьд нийлүүлэлтийн талын хязгаарлалтууд цаашид ч нэмэгдэхээр байна. Тээвэр ложистикийн хүндрэлүүд, барааны эргэлт удааших, хил дээрх хүнд суртал хэвээр, бизнесийн орчны реформ огт хийгдэхгүй байна.



Эдийн засагч
Ж.ДЭЛГЭРСАЙХАН:

Мөнгөний бодлогын хороо өнөөгийн нөхцөл байдалд ийм шийдвэр гаргах шаардлага бий. Уналтаас сэргэж буй эдийн засгийн сэргэлт, цаг үеийн нөхцлөөс шалтгаалсан нийлүүлэлтийн хүчин зүйлс нь төв банкны үндсэн зорилт болох инфляцад сөрөг нөлөөлөх хандлага байгаа үед бодлогын сонголт нь суурь хүүг нэмэгдүүлэх байж болох талтай.

Гэсэн хэдий ч нөгөө талд эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийг хангах асуудал тулгамдаж байгаа тул энэ чиглэлд хийсэн сонголт шийдвэр гаргасан гэж дүгнэж байна. Монголбанкны зүгээс бодлогын хүүг өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн нөхцөлд байж болох хамгийн доод түвшинд хадгалж байна. Нөгөө талд инфляцыг бид оны сүүлийн хагаст зорилтот түвшинд барьж чадах эсэх нь чухал асуудал болж болзошгүй. Инфляц нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, ялангуяа хүнсний бараа бүтээгдэхүүний хувьд өндөр, энэ нь бага орлоготой өрхүүдэд дарамт болох хандлагатай байгааг анхаарах шаардлагатай.

Эдийн засгаа сэргээхэд хамгийн түрүүнд “Эдийн засгийн хямралын гол шалтгаан болсон цар тахлыг хязгаарлах асуудалд онцгой анхаарах, бүх боломж, нөөцөө чиглүүлэх шаардлагатай юм.



Санхүүч
Г.БАТЖАРГАЛ

Бодлогын хүүг 6% болгож бууруулаад удаагүй байна. Монголбанкны гол бодлогын шийдвэр дунд болон урт хугацаанд тогтвортой байлгахад төвлөрч ажилладаг. Дөнгөж хэрэгжиж эхэлж байхад нь өөрчлөх нь үр дүн багатай. Эдийн засаг хөл хориотой холбоотойгоор уул уурхайгаас бусад салбарт сайн идэвхжиж чадаагүй байна. Хүүг хэвээр хадгалж, улирлын хэлбэлзэлтэй тааруулж эдийн засагт үзүүлэх нөлөөг үргэлжлүүлэх нь зөв. Богино хугацааны инфляцын дарамт байгааг ойлгож байна. Энэ нь Монголбанкны дангаараа шийдэх асуудал биш. Хил гааль, ложистикийн асуудлыг төв банк биш ЗГ, түүний агентлагуудын хариуцаж буй. Тиймээс үүнийг богино хугацааных гэж харж байна.

Ковидтой холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг хил гаалиар сайн нэвтрүүлж чадахгүй байна. ОХУ-ын нүүрсний тээвэр хэвийн үргэлжилж байгаа. Тэнд ковид бий. Харин манай хил гааль гяцчихаад байгаа тул төр засгийн түвшинд БНХАУ-ын талтай ойлголцох асуудал байна.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Монголбанкнаас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй арга хэмжээг хэсэгчлэн сунгах тухай



Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу банкуудад “Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаагаар мөрдүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг **2022 оны 4 дүгээр сарын 01-ний** өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэлээ.



Банкуудад зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг нээлттэй үлдээлээ.



Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг /90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицууллаа.



Банкуудад түр хугацаанд мөрдүүлж байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа болон экспортын аккредитивт хамаарах хөнгөлөлттэй зохицуулалтыг тус тус хэвийн горимд шилжүүллээ.



Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг **2021 оны 12 дугаар сарын 31-ний** өдрийг дуустал хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр дахин хойшуулахаар шийдвэрлэлээ.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

2021.06.23

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, Монголбанкнаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3-р улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм. Тус хорооноос гаргасан шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлаас хийсэн тэмдэглэлтэй танилцана уу.

ТВ9: Инфляцын цаашдын төлөв байдал ямар байна вэ. Төв банкны зорилт орчимд хадгалагдах уу. Өсөх дарамт байгаа бол цаашид ямар бодлого баримтлахаар төлөвлөж байна вэ?

Б.ЛХАГВАСҮРЭН: Инфляцын түвшин 5-р сарын сүүлийн байдлаар улсын хэмжээнд 6.2%, Улаанбаатар хотын хэмжээнд 6.7% байна. Өнгөрсөн он болон энэ оны эхэнд хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотойгоор эдийн засгийн идэвхжил бага байсан. Тэр ч утгаараа инфляц 2-3 хувь буюу нам дор түвшинд хадгалагдаж байв. Улирлын онцлогоор 3, 4-р сараас эдийн засаг идэвхжиж, инфляц өсөх дарамт үүсэх боломжтой талаар 2021 оны нэгдүгээр

улирлын мөнгөний бодлогын хурлаар хэлж байсан. Тиймээс бодлогын хүүг бууруулах эсэхийг ярьж байгаад 6 хувьд хадгалахаар шийдвэрлэж, та бүхэнд мэдээлж байв. Инфляц одоогоор 6% буюу манай зорилтот түвшний дундаж дээр ирчихсэн байна. Бүтцийг нь харвал цөөн хэдэн нэр төрлийн бараа буюу сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, нефтийн үнийн өсөлтөөс хамаарч байна. Бид үүнийг нийлүүлэлтийн шинж чанартай, түр зуурын нөлөөлөл гэж үзсэн учир бодлогын хүүг өсгөлгүйгээр хэвээр нь хадгаллаа. Инфляц цаашид өсөх дарамт байгаа хэдий ч 2022 онд буюу дунд хугацаанд зорилтын түвшинд байна гэж үзэж байна. Эдийн засаг оны сүүлийн хагаст сэргэх хэдий ч инфляц хяналтыг алдах хэмжээнд хүрэхгүй. Хэрэв инфляц зорилтот түвшинээс хэтэрвэл дараагийн шатны бодлогын арга хэмжээнүүд бэлэн, тодорхой стратеги, төлөвлөгөөгөө гаргачихаад байна.

Bloomberg TV: Ковид-19-ийн халдварын тохиолдол өдөрт 2000 давж, эрсдэл нэмэгдэж байгаатай холбоотой дахин хөл хорио тавигдвал дотоодын эдийн засгийн идэвхжил сулрах магадлалтай. Эдийн засгийн өсөлтийн төлөвийг

6.9 хувь гэж тооцож байгаа юм байна. Гол нөлөөлөх хүчин зүйлс нь юу вэ?

Д.ГАН-ОЧИР: Гол өсөлтийг цэвэр экспортын өсөлт бүрдүүлнэ гэж хүлээж байна. Оны эцэст нүүрсний экспорт 28 сая тн, зэсийн экспорт үнийн нөлөөллөөс хамаарч өнгөрсөн оноос өндөр байна гэж үзэж байна. Оюу толгойн баяжмал дахь агууламжийн хэмжээ өмнөх оноос өссөн гэсэн эерэг мэдээлэл бий. Санхүүгийн салбар талаас нь харвал зээлийн өсөлт 15-18 хувь байна гэж үзэж байгаа. Энэ нь хуримтлал, хөрөнгө оруулалт, ДНБ-ий хэмжээг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй гэж харж байна. Мөн Засгийн газрын зардал эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлд нөлөөлж байгаа. Мөнгөний бодлогын хүү нам түвшинд, зээлийн идэвхжил нэмэгдсэн, Монголбанкнаас олгож буй санхүүжилтийн хэрэгслүүд нь шууд болон шууд бус хэлбэрээр эдийн засгийг үргэлжлүүлэн дэмжих суурь төсөөлөлтэй байна.

Тэр утгаараа 2021 онд эдийн засаг 6.9 хувиар өсөхөөр төсөөлсөн. Салбараар нь авч үзвэл уул уурхай, түүнийг дагасан салбарууд илүү өндөр өсөлттэй байх төлөвтэй. Харин хөл хорионд өртөж буй дотоодын зарим салбарын өсөлт нам байх төсөөлөлтэй байна.

Өнөөдөр сонин: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшид ямар нэгэн дарамт үүсэх үү?

Б.ЛХАГВАСҮРЭН: Энэ оны хувьд төлбөрийн тэнцэл 500 орчим сая ам.долларын ашигтай гарахаар байна. Монгол Улсын валютын нөөц 4.9 тэрбум ам.доллартай тэнцэж байна. Энэ нь түүхэн дээд хэмжээ юм. Төгрөгийн ханш энэ он гарснаас хойш 0.02 хувиар чангарсан үзүүлэлттэй байгаа. Тиймээс энэ оныг дуустал, ойрын болон дунд хугацаанд ханшин дээр цочир савлагаа үүсэхгүй гэж харж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөж бидэнд таатай нөхцөл бий болгож байгаа нь мөн хадгалагдах төлөвтэй.

Eagle TV: Ипотекийн зээлийг зогсоосон гэсэн мэдээлэл гарч байсан. Тайлбар өгнө үү?

Б.ЛХАГВАСҮРЭН: Ипотекийн зээл олгогдож байгаа. Он гарснаас хойш 6-р сарын 22-ны байдлаар 414

тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Энэ оны турш ипотекийн зээл тасалдалгүй явна. Өнгөрсөн оны 10-р сараас ипотекийн зээлийн хүү 6% болсон. Эх үүсвэрийн 60 хувийг Монголбанк, 40 хувийг банк өөрөө гаргаж байгаа. Тиймээс хөтөлбөрийн зээл тасралтгүй олгогдож байгаа гэдгийг хэлье.

Gogo.mn: Төв банкны үнэт цаасны үлдэгдэл өссөн байгаа. ТБҮЦ-нд их хэмжээний мөнгө төвлөрсөн шалтгаан юу вэ. Цаашид буурах уу?

Б.ЛХАГВАСҮРЭН: ТБҮЦ дээр 10 их наяд төгрөг төвлөрсөн. Энэ нь банкны хадгаламж эзэмшигч, харилцагчдын мөнгө. Банк энэ мөнгөөр юунд хөрөнгө оруулж, санхүүжүүлэхээ өөрсдөө бие дааж шийдвэр гаргадаг. Энэ утгаараа зээлд гаргаж, бонд, үнэт цаас худалдаж авах зэргээс ТБҮЦ-нд байршуулах шийдвэр гаргасан байна. ТБҮЦ-ны хүү нь 6% буюу харилцах, хадгаламжийн дундаж хүүнээс нэлээн доогуур тул эрсдэл багатай, ашиггүй хэлбэрээр төв банканд байршуулж байна. Бодлогын хүүг 6%-д байлгаж байгаа нь санхүүжилтийн эх үүсвэрийг эдийн засаг руу гаргах зорилготой. Одоогоор зээлийн өсөлт 6.2% байна. 2021 онд зээлийн өсөлтийг 15-18 хувьд хүргэх зорилготой ажиллаж байна.

Д.ГАН-ОЧИР: Төв банк банкуудад тавьдаг шалгуураар нийт активынхаа 25 хувийг "хөрвөх чадвар бүхий" байлгах шаардлагатай тавьдаг. Засгийн газар үнэт цаас гаргахгүй байгаа энэ орчинд ТБҮЦ энэ үүргийг гүйцэтгэх хэрэгсэл болж байна. Энэ утгаараа 10 их наяд төгрөгийн 4 их наяд гаруй төгрөг нь энэ шалгуураар ТБҮЦ дээр байршиж байна. Үлдсэн 5.5-6 орчим их наяд төгрөг нь зээлжих бололцоотой эх үүсвэр юм.


Мөн төгрөг 0 хувийн өгөөжтэй банкин дээр байвал банкууд өгөөж хайх зорилгоор гадаад валютад хөрвүүлэх, долларжилт бий болох эрсдэлтэй. Мөн зээлийн өсөлтийг нэг дор огцом бий болговол эдийн засагт эерэгээс илүү сөрөг үр нөлөөтэй байх эрсдэлтэй. Тиймээс төв банкны үнэт цаасан дээр байгаа зээлжих бололцоотой эх үүсвэрийг алгуур суллаж, идэвхжилийг дэмжинэ гэж үзэж байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2021 оны

M2 мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2021 оны 6 дугаар сард 29.8%-д хүрэв




M2-ийн өсөлт байршуулалт талаас




M2-ийн өсөлт эх үүсвэр талаас



Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 10.3%-иар өсч 19.0 их наяд төгрөгт хүрэв.




2021 оны 6 дугаар сарын байдлаар чанаргүй зээл 10.3%-тай байна.




Зээлийн бүтэц, салбарын ангиллаар



Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл 5,189.5 тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо



101,381

Үүнээс:




74%



26%


Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү (*хөнгөлөлттэй зээл оруулснаар)



Эх сурвалж: Монголбанк

Бодлогын хүү түүхэн доод түвшин 6 хувьд хүрэв.



Эх сурвалж: Монголбанк

2021 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 6.6%-тай гарав



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

УЛААНБААТАР ХОТ



Мах, махан бүтээгдэхүүн
18.5%



Сүү, сүүн бүтээгдэхүүн
15.9%



Төрөл бүрийн өөх, тос
17.3%



Хүнсний ногоо
6.0%



Талх, гурил, будаа
5.6%




Сахар, жимсний чанамал, чихэр, шоколад
4.0%


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

6

Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар




МУ-ын төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 5 сарын байдлаар 231.6 сая ам.долларын ашигтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк

7



МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдал болон эдийн засгийн хөгжилд нөлөөлж, улмаар олон улсын санхүүгийн системд аюул учруулах эрсдэл дагуулж байдаг. Иймд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг дэлхийн улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд эдгээр зөвлөмжийн биелэлтийг тодорхой давтамжтайгаар үнэлдэг.

ФАТФ-аас гаргасан Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох үүрэгтэй бөгөөд тус эрсдэлийг хэрхэн бууруулах, удирдах талаарх бодлого, стратегийг гаргасан байхыг шаарддаг байна. Энэ хүрээнд дэлхийн улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын зөвлөмж стандартуудыг мөрдөх, хууль эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр Үндэсний стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тухайлбал АНУ, БНСУ, Филиппин, Нигер зэрэг улс орнуудын Үндэсний стратеги нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд түлхүү анхаарч байна.

Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.8-д үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний хөтөлбөр боловсруулахаар

тусгасан байдаг. Иймд 2016 онд анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргасан бөгөөд 2017 онд Засгийн газрын 143 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Уг хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлж, улмаар 2020 онд хэрэгжилтийг үнэлсэн.

Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 02 дугаар сараас хийж гүйцэтгэсэн. Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан нийт 11 дэд ажлын хэсэгт 52 байгууллагын 128 төлөөлөгчдөөс бүрдсэн том баг банк, үнэт цаас, даатгал зэрэг салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийсэн.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн үндэсний хөтөлбөрийг боловсруулснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зохистой хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэх юм. Мөн түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр нөлөөг дээшлүүлэх, Шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны ерөнхий бүдүүвч схем



Үндэсний хөтөлбөр нь ФАТФ-аас хийх Харилцан үнэлгээний хүрээнд 5 дахь жилийн явцын үнэлгээний бэлтгэл ажлын суурь болох ач холбогдолтой. Мөн Үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь 2023 оны Явцын үнэлгээгээр Монгол Улс ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон Шууд хэрэгжилтийн 11 шалгуур үзүүлэлтийн үнэлгээг амжилттай ахиулах үндэс болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд Үндэсний хөтөлбөрийг батлахаар тусгасан. Энэ хүрээнд эрсдэлийн үнэлгээний тайлангийн урьдчилсан үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны Үндэсний хөтөлбөр” болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Санхүүгийн мэдээллийн албанаас дараах зорилго, зорилттойгоор боловсруулаад байна.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны Үндэсний хөтөлбөрийн зорилго:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох замаар олон улсын зах зээлтэй холбогдсон, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх.

Үндэсний хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах 10 зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

Зорилт 1	Байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах
Зорилт 2	Гэмт хэргийн мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, яллах, шүүн таслах ажиллагааны чанар болон тоог нэмэгдүүлэх
Зорилт 3	Урьдчилан сэргийлэх чиглэлээр төр, хувийн хэвшил, олон нийтийн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх
Зорилт 4	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн комплаенсийн үйл ажиллагаа, тайлагнах тогтолцооны үр дүнтэй байдлыг сайжруулах
Зорилт 5	Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны чанарыг нэмэгдүүлэх
Зорилт 6	Хяналт шалгалтын чанар болон үр ашигтай байдлыг дээшлүүлэх
Зорилт 7	Зөрчилд дүйцэхүйц, түүнийг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх
Зорилт 8	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах
Зорилт 9	Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
Зорилт 10	Ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчин, хяналт шалгалтын тогтолцоог бий болгох

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Үндэсний хөтөлбөр болон төлөвлөгөөний төсөлд холбогдох саналуудыг тусган, сайжруулалтуудыг хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулан батлуулахаар төлөвлөж байна. Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Энэхүү Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тус тус хангах ач холбогдолтой юм.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

Д.СҮХБААТАРЫН ОДОН

Он: 1945

Жин: 65гр

голч: 5.5см

Эх загвар: Урлагийн гавьяат зүтгэлтэн,
Төрийн шагналт зураач Д.Чойдог



Д.Сүхбаатарын одон нь цул алтан таван хошуу бүхий 5 см-ийн голчтой, тэнгэрийн өнгөт цэнхэр цацрагтай байна. Төв дунд нь жанжин Д.Сүхбаатарын дүрийг үйлдэж дээр нь цацаг бүхий улаан туг, доор нь жижиг таван хошуу бүхий бадам цэцгээр хүрээлжээ. Д.Сүхбаатарын дүрийг бор саарал өнгийн дэвсгэр дээр цагаан алтаар товойлгон үйлдэж, улаан туган дээр алтан үсгээр "Сүхбаатар" гэж бичсэн байна.

Дэлхийн хоёрдугаар дайн дууссантай зэрэгцэн 1945 оны 9 дүгээр сард Японы милитаристуудыг бут цохисон ялалтыг тохиолдуулан төрийн дээд шагнал, одон медалийг боловсронгуй болгож өргөтгөх шаардлага гарчээ. Үүний дагуу Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс БНМАУ-ын төрийн дээд шагнал болох Д.Сүхбаатарын одонг 1945 оны 9 дүгээр сарын 27-ны 78 дугаар тогтоолоор батлан гаргажээ.

Д.Сүхбаатарын одонг бий болохоос өмнө Цэргийн гавьяаны Улаан тугийн одон нь тус улсын хамгийн дээд төрийн шагналд тооцогдож, Улсын баатар цол шагнагдсан хүмүүст хамтад нь олгож байсныг халж Д.Сүхбаатарын одонг дагалдуулж өгдөг болжээ.

Энэхүү одонгоор төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал 6 удаа шагнагдсан байна.



А.ЭНХЖИН: ГАДААД ВАЛЮТЫН ЦЭВЭР ОРОХ УРСГАЛ ӨМНӨХ 5 ЖИЛИЙН ДУНДЖААС 450 САЯ ОРЧИМ АМ.ДОЛЛАРААР ИХ БАЙНА

Гадаад валютын зах зээлийн нөхцөл байдлын талаар Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжинтэй ярилцлаа /2021.06.29/.


-Гадаад валютын зах зээлийн сүүлийн үеийн нөхцөл байдал ямар байгаа талаар мэдээлэл өгөхөөс ярилцлагаа эхэлье.

-Сүүлийн саруудад зах зээлийн хүлээлт тогтвортой байсны дээр экспортын бүтээгдэхүүний үнийн өсөлт, эрэлтийн өөрчлөлтийг даган гадаад валютын орох урсгал сайжирсан нь төгрөгийн ханш тогтвортой байхад голлон нөлөөлж байна. Тодруулбал, 2021 оны эхний 5 сарын байдлаар гадаад валютын цэвэр орох урсгал өмнөх 5 жилийн дунджаас 450 сая орчим ам.доллараар их байна. Мөн үүнээс гадна Монголбанк Ковид 19-ийн хүндрэлийн үед валютын зах дээр огцом савлагааг үүсгэхгүй байх арга хэмжээнүүдийг авч ажилласны үр дүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байж оны эхнээс 0.04%-аар чангараад байна.

-Та гадаад валютын орох урсгал сайжирч байна гэлээ. Чухам ямар хүчин зүйлс үүнд нөлөөлөв. Та энэ талаар дэлгэрүүлж мэдээлэл өгнө үү?

-Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалт хурдацтай хийгдэж, томоохон эдийн засгууд сэргэснээр гадаад эрэлт нэмэгдэж, Монгол Улсын экспортын голлох түүхий эдийн үнэд эерэгээр нөлөөлж байна. Манай Улсын экспортын гол бүрэлдэхүүнүүд болох зэс, нүүрс, төмрийн хүдрийн үнэ 2021 онд 10-аас дээш хувиар өсөөд байна. Тухайлбал, 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар зэсний үнэ 28%-аар, нүүрсний үнэ 11%-аар, төмрийн хүдэр 14%-аар өслөө.

Зураг 1. Олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ*



Эх сурвалж: Блүүмберг

*-Түүхий эдийн 2019 оны 1 дүгээр сарын 1-ны өдрийн үнийг суурь болгож индексжүүлсэн

Мөн үнийн өсөлтөөс гадна экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 82 хувиар сайжирснаар 2021 оны эхний 4 сарын байдлаар зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр зэрэг экспортын гол бүтээгдэхүүний орлого өмнөх оноос өсөж, гадаад худалдааны тэнцэл 535.0 сая ам.долларын ашигтай гарлаа. Ийнхүү түүхий эдийн үнэ болон экспортын хэмжээний өсөлт нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлж байна.

-Тэгэхээр цаашдаа төлбөрийн тэнцлийн ашигтай гарна гэсэн үг үү. Төлөв ямар байна вэ?

-Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.долларын ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 1071 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болсон. Улмаар жилийн дүнгээр төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай гарлаа. Харин 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар төлбөрийн тэнцэл 170 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд 2021 оны эцэст төлбөрийн тэнцэл 580 орчим сая ам.долларын ашигтай гарах төсөөлөлтэй байна.

Зураг 2. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн Засгийн газраас 2020 оны 10 дугаар сард 600 сая ам.долларын бондыг 5.1 хувь буюу харьцангуй бага хүүтэйгээр олон улсын зах зээлд шинээр гаргаж ойрын хугацаанд хүлээгдэж буй Мазаалай, Чингис бондуудын эргэн төлөлтийг санхүүжүүлэхээр болсон бөгөөд 2021 оны 4 дүгээр сард Мазаалай бондын төлбөрийг амжилттай төлж дуусгасан. Энэ нь Монгол Улсын богино хугацааны өрийн дарамтыг бууруулж, гадаад валютын дотоодын захад эерэгээр нөлөөлөхөөс гадна, олон улсын үнэлгээний байгууллагууд болон хөрөнгө оруулагчид эерэг хүлээлттэй байгааг харуулж байна. Үүний нэг тод жишээ бол Фитч агентлаг 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В" хэвээр үлдээж, төлөвийг "Тогтвортой" гэж үнэлж буйгаа зарласан явдал юм.

-Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран "Century" төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бондын санхүүжилтийг хийсэн. Энэ ямар ач холбогдолтой вэ?

Цар тахлын хүндрэлийн энэ үед Засгийн газар зээлжих зэрэглэл ижил түвшинтэй орнуудтай харьцуулахад бага, өмнө нь гаргаж байсан бондуудаас хамгийн бага хүүтэйгээр амжилттай арилжаалсан. Энэхүү бондуудыг гаргасан нь төлбөрийн тэнцэлд учрах

байсан дарамтыг шийдвэрлэж чадлаа. Энэ нь ханш цаашид тогтвортой байх, магадгүй чангарах суурь нөхцөлийг бүрдүүлээд байна. Гадаад валютын нөөц нь даатгалтай адилхан. Аливаа улс оронд янз бүрийн эдийн засгийн хүндрэл тохиолдож болно. Тэгэхээр учирч болзошгүй хүндрэлийн үед зайлшгүй хийх гадаад төлбөрөө нөөцөөсөө төлдөг. Эдийн засгийн хүндрэлийн үед улсаа аваад гарах хэмжээний валютын нөөцтэй байх нь зайлшгүй хийх ёстой зүйл юм.

-Төлбөрийн тэнцэл ашигтай гарч байгаа тул гадаад валютын албан нөөц нэмэгдэх хүчин зүйл болж байна уу. Гадаад валютын албан нөөц хэр хангалттай түвшинд хүрсэн гэж үзэж байна?

-Гадаад валютын албан нөөц 2021 оны 4 дүгээр сарын байдлаар түүхэн дээд хэмжээнд буюу 4.9 тэрбум ам.долларт хүрч, импортын 11 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн. Ийнхүү гадаад валютын албан нөөц нэмэгдэхэд төлбөрийн тэнцэл ашигтай байгаа нь эерэгээр нөлөөлөхөөс гадна Монголбанкны үнэт металл худалдан авалт чухал нөлөө үзүүлж байна. Монголбанк сүүлийн 5 жилд нийт 100.0 гаруй тонн үнэт металл худалдан авсан бөгөөд 2020 онд түүхэн дээд хэмжээнд буюу 23.6

тонн үнэт металл худалдан авсан. Харин 2021 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 4.3 тонн үнэт металл худалдан аваад байна. Ингэснээр гадаад валютын албан нөөц нэмэгдэж улмаар олон нийтийн төгрөгт итгэх итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөлөх, эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.

-Цаашид төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ямар байх төлөвтэй байна вэ?

-Манай улсын экспортын 90 орчим хувийг уул уурхайн түүхий эд бүрдүүлдгийн хувьд ханшийн төлөв гадаад эдийн засаг дахь түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг. Голдман сакс зэрэг санхүүгийн томоохон байгууллагууд, мэргэжлийн шинжээчид цар тахлын дараа АНУ, БНХАУ болон бусад хөгжингүй улс орны эдийн засаг идэвхжиж, дэд бүтэц, бүтээн байгуулалт, түүн дотор ногоон хөрөнгө оруулалт ихээр хийгдэх хүлээлттэй байгаагаас түүхий эдийн үнийн дараагийн суперцикл эхэлсэн талаар мэдэгдэж байна. Мөн томоохон хөрөнгө оруулагчид эрсдэлээ тархаах зорилгоор их хэмжээний таваарын гэрээ хэлцэл байгуулж байгаа зэрэг нь Монгол

улсын экспортын голлох түүхий эд болох алт, зэс, төмрийн хүдрийн үнийн өсөлт үргэлжилж, цаашид ч хадгалагдахаар байгааг харуулж байна.


Түүнчлэн, манай орны экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүд болох Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт болон Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтууд ашиглалтад орсноор экспортын хэмжээ огцом нэмэгдэх хүлээлттэй байна. Мөн ойрын хугацаанд хүлээгдэж буй томоохон гадаад өр төлбөр байхгүй бөгөөд дээр дурдсаны дагуу гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдэх төлөвтэй байна.

Эдгээрээс дүгнэхэд төгрөгийн ам.доллартой харьцах ханш цаашид тогтвортой байх төлөвтэй байна. Оны эхнээс төгрөгийн ханш бага зэрэг чангарсан үзүүлэлттэй байгаа. Цаашид дотоод болон гадаад орчны эерэг өөрчлөлтүүд хэвээр хадгалагдсан тохиолдолд төгрөгийн ханш үргэлжлэн чангарах ч боломжтой юм.


- Тодруулга өгсөн Танд баярлалаа.

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2021/07/09-ний хооронд 3,187.8 сая ам.долларын болон 178.4 сая юанийн нийт 1829 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 15/VI ӨДРИЙН БАЙДЛААР)



Монголбанк 2021 оны 6 дугаар сард 2.3 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 9.3 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1.5 тн-оор буурсан үзүүлэлт юм.

2021 оны 6 дугаар сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 112.5 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 107 кг үнэт металл худалдан авсан.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 2021 оны 6 дугаар сард 167,924.18 төгрөг байлаа.


Зураг 1. 2018-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Зураг 2. 1990-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)




Зураг 3. 2021 оны 6 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)



УЛС ОРНУУДЫН ИНФЛЯЦЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлаас шалтгаалан 2020 онд глобал эдийн засаг 3.5 хувиар агшсан нь 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн том хэмжээний эдийн засгийн уналт боллоо. Цар тахлын үеэр улс орнуудын инфляц зорилтоос бага түвшинд байсан бол 2021 оны 2-р улирлаас огцом нэмэгдсэн нийтлэг дүр зурагтай байна. Ерөнхий дүнгээр үзвэл дэлхийн инфляц¹ энэ оны 1-р сард 2.1 хувь байсан бол 6-р сард 4.1 хувьд хүрч даруй 2 дахин нэмэгджээ.

Зураг 1. Улс орнуудын инфляц болон тэдгээрийн зорилтоос давсан хэмжээ



Эх сурвалж: Bloomberg


Дэлхийн болон худалдааны гол түнш орнуудад инфляц нэмэгдсэн нь импортын инфляцыг үүсгэж байна. ОХУ-д инфляц 6.5 хувьд хүрч зорилтот түвшин болох 4 хувиас давжээ. Мөн дэлхийн 2 дахь том эдийн засаг болох БНХАУ-ын инфляц харьцангуй нам түвшинд байгаа хэдий ч өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ оны 1-р сард тус улсын инфляц -0.3 хувь байсан бол 6-р сард 1.1 хувьд хүрч өсжээ. Олон улсын шинжээчдийн тооцооллоор улс орнуудын инфляц ирэх саруудад үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй бөгөөд үүнд суурь үеийн нөлөө, дэлхийн эдийн засгийн сэргэлтийг дагасан эрэлтийн хүчин зүйлс, түүхий эд, хүнсний үнийн өсөлт болон дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний доголдол, тээврийн зардлын өсөлт зэрэг нь нөлөөлөхөөр байна.

Суурь үеийн нөлөө: Түр зуурын, шилжилтийн үеийн шинжтэй суурь үнийн (Base effects) нөлөө өнөөгийн болон ойрын ирээдүйн инфляцыг нэмэгдүүлж байна. Цар тахлаас шалтгаалан улс орнууд 2020 оны эхэн үеэс эхлэн хөл хорио тогтоосноор ААН, бизнес эрхлэгчдийг үйл ажиллагааг хязгаарлаж, эдийн засгийн идэвхжлийг сулруулсан. Улмаар эрэлт буурч, эрэлтийн шалтгаантай

¹ Жигнэсэн дундаж дүнгээр

Улс орнуудын инфляц хямралын үеийн доод түвшнээсээ дунджаар 2-4 нэгж хувиар өсчээ. Тухайлбал, АНУ-д инфляц 1-р сард 1.4 хувь байсан бол 6-р сард 5.4 хувьд хүрчээ. Энэ нь Холбооны Нөөцийн банкнаас зарласан зорилтот 2 хувийн инфляцын түвшнээс бараг 3 дахин их дүн юм. Түүнчлэн, Евро бүсийн инфляц 2021 оны 6-р сард 1.9 хувьд хүрсэн нь мөн л сүүлийн 2 жилд байгаагүй өндөр үзүүлэлт болж байна.

Зураг 2. Сонгогдсон улсуудын инфляцын динамик



үнийн өсөлт саарахын зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурсан нь үйлдвэрлэгчийн зардлыг хямдруулах нөхцөлийг бүрдүүлж байв. Ийнхүү 2020 онд үнийн өсөлт бага байсан суурь нөлөө нь хэрэглээний үнийн индексийн өсөлтийн хувь буюу инфляцыг энэ онд өндөр харагдуулах нэгэн хүчин зүйл болж байна.

Эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө: Хүн амыг вакцинжуулах үйл явц эрчимжиж, иргэд олон нийт идэвхтэй хамрагдан хөл хориог бүрэн болон хэсэгчилсэн байдлаар сулруулж эхэлсэн нь дэлхийн эдийн засгийн сэргэлтийг түргэсгэж байна. Сүүлийн улирлуудад томоохон эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлт хүлээлтээс даван дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл сайжирсан, зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж эрэлтийн шалтгаантай инфляцын эрчийг нэмэгдүүлэх хандлагатай боллоо. Ялангуяа үйлчилгээний салбарт үнийн өндөр өсөлт олон улсад ажиглагдаж байгаа нь нэг талаас иргэд олон сар үргэлжилсэн хөл хорионы дараа иргэд олон нийтийн газраар үйлчлүүлэх сонирхол нэмэгдсэн, нөгөө талаас удаан хугацаанд үйл ажиллагаа нь хязгаарлагдсан үйлчилгээний байгууллагууд зардал нэмэгдэж үнэ өсөх нөхцөлийг бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Гадаад эдийн засгийн өсөлтийн 2021 оны төсөөлөл (МБХ-нд танилцуулсан)


Төсөөлөл хийсэн огноо	2020 оны 9-р сар	2020 оны 12-р сар	2021 оны 3-р сар	2021 оны 6-р сар
Дэлхийн эдийн засгийн өсөлт	5.3%	5.1%	5.6%	6.1%
Хятадын өсөлт	8.1%	8.2%	8.3%	8.5%
АНУ-ын өсөлт	4.2%	3.5%	4.5%	6.1%
Евро бүсийн өсөлт	5.9%	5.4%	3.9%	4.3%
ОХУ-ын өсөлт	2.9%	3.2%	3.0%	3.1%
Хөгжингүй эдийн засгууд*	3.9%	4.3%	5.1%	5.6%
Хөгжиж буй болон Эрчимтэй хөгжиж буй эдийн засгууд*	6.0%	6.3%	6.7%	6.3%

Эх сурвалж: ОУВС, Дэлхийн Банк, EIU, Блүүмберг, Рубини байгууллагуудын төсөөллийн дундаж

*ОУВС-гийн 2020 оны 10-р сар, 2021 оны 1, 4, 7-р сарын төсөөлөл

Түүхий эд, материалын үнийн нөлөө: Дэлхийн эдийн засаг сэргэн аж үйлдвэрлэл нэмэгдэж түүнийгээ дагаад түүхий эд, материалын их хэмжээний эрэлтийг бий болголоо. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өссөн нь эрчим хүч, шатахуун, барилгын материалын үнийг өсгөж улмаар үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх шалтгаан болов. Тухайлбал, 2020 оны 3 дугаар сард газрын тосны үнэ огцом буурч 1 баррель Брент газрын тосны үнэ 23 ам.доллар байсан бол 2021 оны 6 сард 75 ам.доллартой тэнцэж, төмрийн хүдэр, зэс түүхэн дээд үнэдээ хүрсэн билээ. Инфляцыг нийлүүлэлтийн шинжтэй бүтээгдэхүүнээр ялган харвал дийлэнх орнуудын хувьд түлш, шатахуун, эрчим хүчний бүтээгдэхүүний өсөлт хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн, ирэх улирлуудад түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдах хүлээлттэй байгаа тул үйлдвэрлэгчийн зардал нэмэгдэх, улмаар үнэ өсөх нөхцөлийг үүсгээд байна.


Зураг 3. Дотоодын шатахууны үнэ болон олон улсын брент газрын тосны үнэ



Эх сурвалж: Монголбанк, YCX, Bloomberg

Хүнсний инфляц: 2020 онд КОВИД-19-ийн нөлөөгөөр улс орнуудын хүнсний бус инфляцын түвшин буурсан боловч хүнсний инфляц цар тахлын өмнөх үеэс өндөр байж, инфляцыг нэмэгдүүлэх нөлөөтэй байв. 2021 он гарснаар хөл хорионы дэглэм буурч хүнсний тээвэрлэлтэд үүссэн хүндрэлүүд арилж, хүнсний нийлүүлэлт тогтворжиж байгаа хэдий ч цаашид эрэлт үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй тул дэлхий зах зээл дээрх гол хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ өндөр түвшинд хадгалагдахаар байна.

Зураг 4. Олон улсын хүнсний индекс, түүний дэд бүлгүүдийн жилийн өсөлт



Эх сурвалж: FAO

Тээвэр, логистикийн түгжрэл, тээврийн зардлын өсөлт нь инфляцыг нэмэгдүүлэх нийлүүлэлтийн бас нэгэн хүчин зүйл болж байна. Upfly компанийн 2021 оны 2-р сарын тоон мэдээнээс харахад Ази-Европын корридорын далайн тээврийн үнэ сүүлийн 1 жилийн дотор 91 хувиар өссөн бол тус корридорын агаарын тээврийн үнэ 61 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн, БНХАУ-аас экспортлогдож буй ачаа тээврийн үнийг илэрхийлэх CCFI индекс өмнөх оны мөн үеэс 120 хувиар өсжээ. Үүнээс хойш тээврийн үнэ буураагүй бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. Тээврийн үнэ нэмэгдэж байгаа голлох шалтгааныг авч үзвэл:

- КОВИД-19 цар тахал дэгдсэнээр үйлдвэрлэл болон эрэлтийн тэнцвэргүй байдал бий болсон. Цар тахал дэгдсэний дараа улс орнууд хилээ хааж, зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ сааруулсан нь олон улсын тээвэр гүйцэтгэдэг компаниудад тээвэрлэх барааны хомсдолыг үүсгэж байсан бол зарим саруудад үйлдвэрлэл нэмэгдсэнээр бараа тээвэрлэх сул чингэлэгийн хомсдол бий болж байна.
- Далайн тээврийг орлох өөр хувилбар байхгүй. Далайн тээврийг орлох өөр хямд өртөгтэй тээврийн


хувилбар байхгүй тул одоо үүсээд буй тээврийн зардлын өсөлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байна. Хэдийгээр агаарын тээврийн хэрэгсэл болон галт тэргийг ашиглаж болох ч тээж чадах ачааны хэмжээ харьцангуй хязгаарлагдмал бөгөөд цар тахлын энэ үед тэдгээрийн зардал мөн өссөн юм.

- Улс орнуудын эдийн засаг тэнцвэргүй (харилцан адилгүй) сэргэж байна. Зарим улсуудын экспортын хэмжээ аль хэдийн цар тахлын өмнөх үеийг давсан байхад зарим улсуудад экспорт бүрэн сэргээгүй байна. Энэхүү тэнцвэргүй өсөлтөөс шалтгаалж ойрын саруудад ачаагүй чингэлэгийн тээвэрлэлт зэрэг худалдааны салбар, олон улсын тээврийн хүндрэлтэй асуудал үргэлжлэхээр байна. Энэ нь эргээд тээврийн зардал нэмэгдэхэд нөлөөлж байна.
- Төлөвлөсөн далайн тээвэр цуцлагдах аль эсвэл хойшлогдсоноос шалтгаалж далайн боомтуудад бөөгнөрөл үүсээд байна. Хэдийгээр энэ оны 4-р

сараас хойш төлөвлөсөн цагтаа очиж байгаа далайн тээврийн тоо эхний улирлынхаас нэмэгдэж байгаа ч сүүлийн 10 жилийн хамгийн доод түвшинд хэвээр байна. Хэвийн үед нийт онгоцны 70-аас 80 хувь нь төлөвлөсөн цагтаа очдог бол хамгийн сүүлийн мэдээгээр 40 гаруй хувьтай байна.

- 2021 оны 3-р сард Дэлхийн худалдааны 12 хувь орчим дайран өнгөрдөг, Ази-Европыг холбосон хамгийн богино далайн холбоос болох Суэцийн сувагт Evergreen компанийн онгоц гацаж 6 хоногийн турш олон улсын далайн тээвэрт саад учирч, тээвэр удаашрахад нөлөөлсөн.
- Өмнө нь тохиолдсон худалдааны хямралуудтай харьцуулахад КОВИД-19 цар тахлын үед гадаад худалдаа илүү богино хугацаанд эргэн сэргэж, цаашид тогтвортой өсөх төсөөлөлтэй байна. Тухайлбал, 2021 оны эхний улирлыг харахад ихэнх бүс нутагт экспорт, импортын биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд² хүрч сэргээд байна (Зураг 5).

Зураг 5. Бүс нутгуудын экспорт, импортын биет хэмжээний индекс



Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

Дээрх хүчин зүйлс нэгэн зэрэг эдийн засагт илэрч байгаа нь сүүлийн саруудад дэлхий нийтээр инфляц хурдтай нэмэгдэх шалтгаан болж байна. Инфляцыг онилох мөнгөний бодлого хэрэгжүүлдэг төв банкууд эрэлтийг үйлдвэрлэлийн потенциал түвшинтэй нь нийцтэй удирдах замаар инфляцыг зорилтот түвшинд

нь хадгалдаг. Иймээс ихэнх төв банкууд бодлогын зөөлөн төлөвөө хадгалж, богино хугацааны үнийн өөрчлөлтөд хариу үзүүлэлгүй хүлээцтэй хандаж байна.

² 2020 оны 1-р улирлыг хэвийн үеийн түвшин гэж тооцов.

Дурсгалын 10000—ТЫН МӨНГӨН ДЭВСГЭРТ ГАРГАЛАА



Монголбанк Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулан гүйлгээнд хүчин төгөлдөр дурсгалын 10000 төгрөгийн мөнгөн дэвсгэртийг цөөн тоогоор үйлдвэрлэж, 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдөр гаргаад байна. Энэхүү 10000-тын дэвсгэрт нь УИХ-аар баталсан мөнгөн дэвсгэртийн загвар, тодорхойлолтын дагуу бүх хэв шинжийг агуулахын зэрэгцээ сүүлийн үеийн шинэ технологиор бүтээгдсэн хамгаалалтын элементүүдээр баяжигдсан гэдгээрээ онцлог юм.

Дэвсгэртийн нүүрэн талд байрлуулсан Ардын хувьсгалын 100 жилийн ойн лого болон баруун, доод хэсэг дэх морьтон баатар нь 3D хэмжээст, өнгө нь хувирч солонгорох хамгаалалтын шинэ технологи бөгөөд баруун, зүүн ирмэгт харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 7 ширхэг ташуу зураасан товгор таних тэмдэгтэй болно. Дэвсгэртийн ар талд Д.Сүхбаатар жанжны хөрөг болон Ардын хувьсгалыг тунхаглан зарлах үед ард олонд хандаж хэлсэн алдарт үгийг оруулж, “Ардын хувьсгал 100 жил” гэсэн бичвэр бүхий тасалдаж харагдах металл утсыг байрлуулж, хэт ягаан туяаны гэрэлд тодорч харагдах Соёмбыг нүүрэн талд,

Монгол Улсын газрын зургийг ар талын зүүн дээд хэсэгт тус тус байрлууллаа. Түүхэн ой, үйл явдлыг тэмдэглэх дурсгалын мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах нь дэлхийн улс орнуудад түгээмэл байдаг нийтлэг жишиг болно.

Төв банкны тухай хуулиар Монголбанк мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлдэг бөгөөд нөөцийг нь шинээр бүрдүүлэх шаардлагатай болсон мөнгөн тэмдэгтүүдийг шинэ дэвшилтэт технологиор хийгдсэн өндөр нууцлал бүхий хамгаалалтын элементүүдээр сайжруулахад тогтмол анхааран ажиллаж байна. 2018 онд 5000 төгрөгийн дэвсгэртийн Соёмбыг солонгорч харагдах бэхэн элемент болгон сайжруулж, 2019 онд 50, 20000 төгрөгийн дэвсгэртэд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор элемент, солонгорч харагдах бэхэн элемент шинээр нэмж, 20000 төгрөгийн дэвсгэртийг гурван хэмжээст, микро оптик, хөдөлгөөнт гадаргуутай цоо шинэ туузтай болгож, 2020 онд 100, 500, 1000 төгрөгийн дэвсгэртүүдэд солонгорч харагдах бэхэн элемент, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор элементтэйгээр шинэчлэн сайжруулав.

"CENTURY" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ӨРИЙН ДАХИН САНХҮҮЖИЛТИЙГ АМЖИЛТТАЙ ХИЙЛЭЭ

Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран 2021 оны зургаадугаар сарын 29-ний өдөр өрийн удирдлагын стратегийн "CENTURY" төслийн хүрээнд арилжаалсан 1 тэрбум ам.долларын бонд нь манай улсын ирэх хоёр жилийн хугацаанд хүлээгдэж байсан гадаад өрийн үндсэн төлбөрийг хойшлуулж, төсвийн болон төлбөрийн тэнцлийн богино хугацааны эрсдэлийг бууруулж, хөрвөх чадварыг сайжруулж байна. Уг бондын арилжаагаар 2022 онд төлөгдөх 799 сая ам.долларын үлдэгдэл төлбөртэй "ЧИНГИС" бонд, 2023 онд төлөгдөх 800 сая ам.долларын "ГЭРЭГЭ" бондуудыг хэсэгчлэн дахин санхүүжүүлж, 2022-2023 онд МОНГОЛ УЛСААС ГАРАХААР ХҮЛЭЭГДЭЖ БАЙСАН ВАЛЮТЫН ТӨЛБӨРИЙГ 1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРААР буурууллаа. Энэхүү дахин санхүүжилт нь КОВИД-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлтийг түргэсгэх бодлогыг хэрэгжүүлж буй үед Монгол Улсын гадаад төлбөрийн чадвар, валютын урсгалд чухал дэмжлэг болж байна.

Тодруулбал, 6 жилийн хугацаатай, 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай, 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.долларын санхүүжилт босгоод байна.

Олон улсын хөрөнгө оруулагчид түүхэн бага хүүгээр гаргасан урт хугацаатай бондоор "ЧИНГИС", "ГЭРЭГЭ" бондыг дахин санхүүжүүлэх хэлцэлд орсон нь хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол Улсад итгэх итгэл өндөр байгааг илтгэж байна. Монгол Улсын Засгийн газар, Төв банкнаас сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудтай нийцэж, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээхийн зэрэгцээ улсын зээлжих зэрэглэл сайжрахад нөлөөлнө гэж харж байна. Ийнхүү гадаад өрийн удирдлага, стратеги сайжирснаар сүүлийн жилүүдэд томоохон дүнтэй бондуудыг бага хүүгээр амжилттай арилжаалах замаар Засгийн газрын өндөр хүүтэй бондыг дахин санхүүжүүлж, гадаад өрийн төлбөрийн дарамтыг бууруулж байна.

Энэ талаар Сангийн сайд Б.Жавхлан дараах тодруулгыг өгөв.



Сангийн сайд **Б.ЖАВХЛАН**

Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулагчдаас ирсэн санал нь тухайн үнэт цаасны дүнгээс 2.5-3 дахин их ирсэн тохиолдолд амжилттай боллоо гэж үздэг. "Century" төслийн хүрээнд нийт 6.4 тэрбум ам.доллар буюу санал болгосон хэмжээнээс 6.4 дахин илүү саналыг Ази, Америк, Европын хөрөнгө оруулагчдаас ирүүлээ. Мөн манай улстай ижил зээлжих зэрэглэлтэй улсууд шинээр бонд гаргахад дунджаар 7-8 хувийн хүү төлж байхад манай улс В үнэлгээтэй улсуудаас хамгийн бага буюу 3.5-4.45 хувийн хүүтэйгээр өмнөх бондуудыг дахин санхүүжүүлсэн. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын цар тахлын үед эрүүл мэнд, эдийн засгаа аврах зорилгоор хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний үр дүнгийн илрэл бөгөөд олон улсын хөрөнгө оруулагчдын Монгол Улсын улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд итгэх итгэл өндөр байгааг харуулж байна.

Засгийн газар хугацаа тулсан, өндөр дүнтэй гадаад өр төлбөрийг хойшлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх жилүүдэд үүсэх байсан өрийн дарамтыг бууруулж, гадаад валютын ханшийг тогтвортой барихад эерэг нөлөө үзүүлэх төдийгүй Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад чухал нөлөөтэй юм.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ШИНЖИЛГЭЭ¹

Б.Баярдаваа², Б.Дуламзаяа³
(2021 оны 5-р сар)

Энэхүү судалгааны ажлаар манай эдийн засгийн гадаад секторын өнөөгийн байдал, төлөв, гадаад валютын орох, гарах урсгалын шинжилгээ, гадаад секторын хараат байдлын шинжилгээ, гадаад секторын эмзэг байдлын шинжилгээг хийж, бодлогын түвшинд цаашид анхаарах асуудлуудыг авч үзлээ. Судалгааны ажлын тооцоолол, шинжилгээг хураангуйлан дүгнэвэл:

- **Эдийн засгийн гадаад секторын төлөвийг** харахад дотоод санхүүгийн хуримтлалаас давсан хэрэглээ, хөрөнгө оруулалт нь урсгал тэнцлийн ужгирсан алдагдлыг үүсгэсээр байна (Зураг 1-2). Урсгал тэнцэл тогтмол алдагдалтай, түүнийг гадаад өрөөр санхүүжүүлж, гадаад өр өсөн нэмэгдэж буй байдал нь олон улсын зах зээлийн төлвөөс улам өндөр хамааралтай болгож байна (Зураг 3). Урсгал тэнцлийн алдагдал багасах суурь нөхцөл бүрдээгүй тул ирээдүйд түүхий эдийн үнэ буурах, эдийн засгийн идэвхжлийг даган импортын эрэлт нэмэгдэх үеүдэд урсгал тэнцлийн алдагдал улам тэлж болзошгүй байна. Урсгал тэнцлийн алдагдлыг 2024 оныг хүртэл голчлон Оюу толгойн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, төлбөрийн тэнцэл ирэх онуудад эерэг орох урсгалтай байх төлөвтэй. Гэхдээ цар тахлын дотоод дахь тархалтын нөхцөл байдал хэрхэн өрнөхөөс экспорт, ГШХО зэрэг гадаад валютын орох урсгалууд хүчтэй хамаарахаар байна.

- **Төлбөрийн тэнцлийн томоохон урсгалуудыг тоймлон авч үзвэл⁴** 2020 онд нийт орох урсгал 12.2 тэрбум ам.доллар, нийт гарах урсгал 11.2 тэрбум ам.доллар бөгөөд нийт төлбөрийн тэнцэл 787 сая ам.долларын ашигтай гарчээ. Манай Улсын гадаад валютын гарах томоохон урсгалууд нь импортын төлбөр (5.2 тэрбум \$), үйлчилгээний зардал (2.1 тэрбум \$), гадаад зээл, бондуудын үндсэн төлбөр (2.8 тэрбум \$) болон хүүгийн төлбөр (0.9 тэрбум \$), ногдол ашгийн төлбөр (0.2 тэрбум \$) зэрэг байна. Харин эдгээр гадаад валютын гарах урсгалыг бид экспортын орлого (7.0 тэрбум \$), үйлчилгээний орлого (0.7 тэрбум \$), гадаадын шууд хөрөнгө оруулалт (1.4 тэрбум \$), гадаад бондын арилжаа (600 сая \$) болон гадаад зээл (2.3 тэрбум \$) гэсэн орох урсгалаар санхүүжүүлжээ.
- **Гадаад секторын хараат байдлын шинжилгээг** дүгнэхэд манай эдийн засаг гадаад эрэлт, дэлхийн санхүүгийн зах зээлийн төлөв, түүхий эдийн үнэ, ГШХО-оор дамжин гадаад орчноос хамаарах хамаарал өндөр бөгөөд тиймээс ч гадаад шокын дотоод эдийн засагт үзүүлэх нөлөө хүчтэй байна. Гадаад худалдаанаас хараат байдал өндөр (Зураг 5), экспортын төрөлжилтөд төдийлөн ахиц гараагүй байна (Зураг 4)⁵. Гадаад орчноос хамааралтай байдлыг бууруулахад түүхий

¹ Энэхүү судалгаа нь зөвхөн судлаачдын байр суурийг илэрхийлнэ.

² Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал

³ Монголбанкны Мөнгөний бодлогын газарт ахлах эдийн засагч

⁴ Үүнд орох, гарах урсгалаар ангилах боломжгүй, тохиромжгүй болон бага дүнтэй үзүүлэлтүүд болох төлбөрийн тэнцлийн алдаа, орхигдуулга, бэлэн мөнгө, харилцах, хөрөнгийн данс, худалдааны зээл, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн дүнг тусгаагүй болно.

⁵ 2020 оны байдлаар уул уурхайн экспорт нийт экспортын 93 хувийг, түүхий эдийн экспорт нийт экспортын 95.6 хувийг бүрдүүлж байна. Экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс сүүлийн 15 жилд 0.3-0.4 орчимд, 2020 оны сүүлийн улиралд 0.32 байгаа нь экспортын төвлөрөл өндөр (төрөлжилт муу), сүүлийн 15 жилд ахиц гараагүй байна.

эдийн үнийн хэлбэлзлийг бууруулах мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх, дунд хугацаанд экспортыг төрөлжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хараат байдлыг багасгах, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах эдийн засгийн бүтцийн шийдэл, бодлогууд шаардлагатай байна. Орлого нэмэгдэхэд импорт илүү хурдаар нэмэгдэж байгаагаас валютын гадагшлах урсгал нэмэгдэж байна.

- Манай улсын **гадаад секторын эмзэг байдлын** харьцаа үзүүлэлтүүдийг ОУВС-гийн диагностик **шинжилгээний** жишиг аргачлалд тулгуурлан тооцож, босго утгуудтай харьцуулан шинжлэхэд гадаад худалдааны төрөлжилт муу, урсгал тэнцэл тогтмол алдагдалтай, түүнийг гадаад зээл, бондоор санхүүжүүлж ирснээр гадаад хөрөнгө оруулалтын позицын өглөг болон гадаад өр хуримтлагдсан нь эмзэг байдал өндөр байх суурь шалтгаанууд болж байна (Хүснэгт 1). Төв банк гадаад валютын нөөцийг сүүлийн 3 жилд хуримтлуулж, гадаад валютын нөөцийн хүрэлцээ нэмэгдэж байгаа ч ОУВС-гийн АRA метрикс аргачлалын дагуу нөөцийн зохистой түвшинд хараахан хүрээгүй байна (Зураг 8).
- **Гадаад өрийн тогтвортой байдлын суурь төсөөллөөр** гадаад өрийн түвшин дунд хугацаанд тогтвортой байх хандлагатай байгаа хэдий ч түүхий эдийн үнэ буурах, эдийн засгийн өсөлт саарах, хүү өсөх, ханш сулрах зэрэг макро шокууд нь гадаад өрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна (Зураг 9). Иймд гадаад өрийн тогтвортой байдлыг хангахад макро эдийн засгийн суурийг бэхжүүлэх, тогтвортой бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

Бодлогын анхаарах асуудлууд

Эдийн засгийн шокиг шингээх эсхүл түүний сөрөг үр дагаврыг хохирол багатай даван туулах чадвар, дархлааг бэхжүүлэхийн тулд гадаад тэнцвэрийг худалдааны тэнцэл болон гадаад өрийн удирдлагыг

хослуулах байдлаар бүрдүүлэх нь зүйтэй байна. Энд эдийн засгийн шокиг саармагжуулах болон шингээх чадварыг сайжруулах, хөрөнгийн урсгалын хэлбэлзлийн сөрөг нөлөөг бууруулахад гадаад валютын нөөцийг нэмж хуримтлуулах, үүнийг зохицуулалттай-хөвөгч валютын ханшийн бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Гадаад сөрөг шокын үед харьцангуй уян хатан ханшийн бодлого барьснаар валютын ханш тодорхой хэмжээний шок шингээгчийн үүрэг гүйцэтгэж (экспортыг дэмжиж, импортын хурдыг сааруулах), гадаад худалдаанд чөлөөт зохицуулалт хийгдэж, эдийн засгийн дотоод, гадаад суурь нөхцөл засагдах юм.


Дунд, урт хугацаанд эдийн засгийн гадаад орчноос хараат байдлыг бууруулан, гадаад, дотоод тэнцлийг хангаж, эдийн засгийн төрөлжилтийг бодлогыг эрчимжүүлэх нь чухал байна.

Мөн гадаад валютын нөөц зохистой түвшинд хүрээгүй нөхцөлд ойрын хугацаанд хүлээгдэж буй томоохон өр, төлбөрийг аль болох өртөг багатайгаар дахин санхүүжүүлэх шаардлагатай. Үүнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах нь чухал байх болно. Түүнчлэн, гадаад санхүүжилтүүдээс илүү тогтвортой санхүүжилтийн төрлийг сонгох (богино хугацаанд гэнэт гарч явах эрсдэл бүхий зээл, бондоос илүүтэй хөрөнгө оруулалтын хэлбэртэй байх) нь эдийн засагт хөрөнгийн урсгалаас үүдэлтэй хэлбэлзлийг сааруулах ач холбогдолтой.

Эдийн засгийн өсөлт суурь төсөөллөөс саарах, зээлийн хүү өсөх, түүхий эдийн үнэ буурах, ханш сулрах зэрэг шокууд нь гадаад өрийн динамикт сөрөг нөлөөтэй тул гадаад өрийн тогтвортой байдлыг хангахад макро эдийн засгийн суурийг бэхжүүлэх, тогтвортой бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

Судалгааны ажлын дэлгэрэнгүй тооцоо, шинжилгээг Мөнгө, Санхүү, Баялаг сэтгүүлийн 2021 оны № 24, 15-32-р хуудас буюу доорх линкээр орж, танилцаж болно. https://www.mongolbank.mn/documents/MSB_setguul/MB_sanhuu24.pdf


Зураг 7. Том дүнтэй гадаад бонд, зээл, бусад санхүүжилтийн орох үрсгалууд, сая \$-р




Эх сурвалж: Монголбанк

Жич: Дээрх зураг Хуралдай, Гэрэгэ, Номад, ER бондын дүнгүүдээс өмнөх бондыг дахин санхүүжүүлсэн дүнг цэвэрлэж харуулсан болно.

Зураг 8. Гадаад валютын албан нөөцийн хүрэлцээ, ОУВС-гийн ARA метрикс



Зураг 9. Гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээ



Хүснэгт 1. Гадаад секторын эмзэг байдлын харьцаа үзүүлэлтүүд

[illegible]


Эх сурвалж: Сүдлаачийн тооцоолол

ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА “ЗАЛИЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Цахим хэрэгсэл ашиглан, цахим орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн хувьд энэ нь Монгол Улсад шинээр бүртгэгдэж байгаа гэмт үйлдлийн арга ба ихэвчлэн фэйсбүүк хаяганд хууль бусаар нэвтэрч таны ойр дотны хүнээс мөнгөн тусламж хүссэж залилах, зээл чөлөөлөх, зээл олгох нэрээр таниас урьдчилгаа төлбөр байршуулахыг шаардах, цахим орчинд үр дүнг урьдчилан таах боломжгүй мөрийтэй тоглоом, азын суглаа явуулах, бараа бүтээгдэхүүн худалдах нэрээр урьдчилгаа байршуулахыг шаардах зэрэг хэлбэрээр үйлдэгдэж байна. Монгол улсын хилийн гаднаас гадаад улсын гэмт бүлэглээс Монгол Улсад үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэг баггүй хувийг эзэлж байна. Энэ нь цахим шуудангийн луйвар, романс луйвар, хөрөнгө оруулалтын залилан буюу таны бизнесийн үйл ажллагаанд шаардагдах хөрөнгө оруулалтын зээл олгох, Негирийн захидал буюу өв залгамжлалын залилан, урьдчилгаа төлбөрийн залилан, банкны залилан үйлдэгддэг.

Цахим шуудангийн луйвар: Манай улсын гадаад худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд харилцагч талаас ирсэн цахим шууданд төлбөрийн данс солигдсон, өөрчлөгдсөн үндэслэлээр өөр дансанд төлбөрийг шилжүүлэхийг хүссэн цахим шуудан хүлээж авдаг ба тус шилжүүлгийг хийснээр цахим шуудангийн луйврын хохирогчид болдог. Энэ нь ихэвчлэн таны харилцагч байгууллагын өмнөөс түүний харилцах имэйл хаягтай ижил боловч зөвхөн нэг цэг, тэмдэгтийн байрлалыг сольж хуурамч хаягаас танд төлбөрийн нэхэмжлэл илгээн мөнгө залилаж байна.

Тухайлбал: SEL_SoutheastAsia@sellInc.com хаягаар захиалгаа өгсөн боловч уг мэдээллийг дундаас 3 дахь этгээд олзлон авч имэйл хаягыг SEL_SouthaestAsia@sellInc.com болгож өөрчилөн



ЦАХИМ ШУУДАНГИЙН ЛУЙВРААС ХЭРХЭН СЭРГИЙЛЭХ ВЭ?



Романс луйвар: Интернет орчинд харилцаа тогтоон хүний итгэлийг олж аван улмаар үүнийгээ ашиглан залилангийн гэмт хэрэг үйлдэхийг романс луйвар гэж ойлгож болно.

Хөрөнгө оруулалтын ЗАЛИЛАН /зээл олгох/: Цахим шуудан болон олон нийтийн сүлжээ сайтуудаар маш бага хүүтэй барьцаагүй, баталгаатай зээл гэх утгатай захидал болон нийтлэлүүд нийтлэгддэг. Үүний дагуу хэн нэгэн холбогдоход гэмт этгээд та эхлээд авах гэж байгаа зээлийнхээ тодорхой хувийг шимтгэлд төлөх ёстой, дараа нь та татвараа төлөх ёстой гэх нэрийдлээр луйврын гэмт хэргийг үйлддэг байна.


Анхаар: Хариуцлагатай компани, бизнесмэн нь хэзээ ч танихгүй хүний бизнесийг санхүүжүүлэхээр мөнгө санал болгодоггүй, хэрэв та тэдний аргад өртөн мөнгө шилжүүлсэн тохиолдолд мөнгөө буцааж авах, хохирол барагдуулах ямар ч боломжгүй болохыг анхаарах.



Банкны ажилтан, банкны нэр ашиглан залилах. Таны имэйл хаягт банкны албан ёсны мэт хуурамч имэйл хаяг ирэх ба танаас банкны мэдээлэл асууж, баталгаажуулахыг шаарддаг. Банк хэзээ ч таны хувийн мэдээллийг асууж имэйл явуулдаггүй. Харин гэмт этгээд таны хувийн мэдээллийг өөрийн болгосноор дурын гэмт хэргээ үйлдэх нөхцөл боломж нь бүрдсэн байдаг.

Үнэгүй бараа. Гэмт этгээдүүд онлайнаар олон улсад нэр хүндтэй хүмүүс болон байгууллагын нэрийг барьж та азтан боллоо, та үнэгүй авах боломжтой гэх утга бүхий имэйлийг таны имэйл рүү явуулна. Улмаар та хожсон эсвэл үнэгүй авах боломжтой бараагаа авахын тулд таны кредит карт, гэрийн хаяг болон бусад мэдээллийг асуух болно. Хэрэв та өөрийн мэдээллээ өгсөн тохиолдолд дансан дахь мөнгөө алдах эрсдэлтэй.


Мөн таны хувийн мэйл, гар утас, эсвэл шуудангийн хаягаар тань захиа илгээж, Таныг “Сугалаанд аз таарлаа ..., бэлэн мөнгө хожлоо..., өв залгамжилсан хөрөнгөнөөсөө хувь хүртээж бэлэн мөнгө өгөх гэж байна...” гэх мэт мэдээллүүдийг илгээж, урьдчилгаа болгон танд чек илгээж байна, үлдсэнийг нь авахын тулд татвар, шимтгэл, шуудангийн зардалд гэх зэргээр тодорхой хэмжээний мөнгийг шилжүүлэхийг хүсэх.



Анхаар: Бодит амьдралд сугалаанд та оролцоогүй байхад хонжвор таарах, хэрэв оролцсон бол хонжворыг олон нийтэд мэдээлэхгүйгээр танд хэзээ ч өгөхгүй, мөн өв залгамжлалын хөрөнгийг хуульч, өмгөөлөгчгүйгээр хэзээ ч хэн нэгэнд өгдөггүй!

Дээрх гэмт хэргүүдээс иргэдийн фэйсбүүк хаягийн нэвтрэх нэр, нууц үгийг авах, таах зэргээр хууль бусаар нэвтэрч ойр дотны хүн, найз нөхөд рүү нь эзэмшигчийн өмнөөс чат бичиж мөнгө залилаж байгаа хэрэг ихэвчлэн үйлдэгсээр байна.

Анхаар: өөрийн фэйсбүүкийн нэвтрэх нууц үгийг өөрийн төрсөн огноо, гар утасны дугаар зэрэг тааж мэдэх боломжтой байдлаар хийхгүй байх, нууц үгийг тэмдэгт буюу үсэг, тоо оролцуулан хийх, фэйсбүүкийн нэвтрэх нэр, нууц үгийг оруулж унших мэдээ, мэдээллийг үзэхгүй, хандалт хийхгүй байх, таны ойр дотны хэн нэг хүн таниас мөнгө зээлэх зэрэг хүсэлт илгээсэн тохиолдолд заавал утсаар холбогдож нягтласны дараа үйлдэл хийх.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!

ЗАЛИЛАГЧИД
БОЛОМЖ БҮҮ ОЛГО

Та нууц үгээ санаандгүй хэн нэгэнд
мэдэгдсэн, эсвэл хангалттай сайн
нууцлалтай биш гэж үзэж байвал нууц
үгээ тэр дор нь сольж, цахим залиланд
өртөхөөс сэргийлээрэй.



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!

